



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 467

Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлж, малчин өрхийг мэдээллээр ханган анхан шатны хоршоог байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

(Засаг даргын орлогч)

Гишүүдэд

(Засаг даргын

Тамгын газрын дарга)

(Лүн багийн Засаг дарга)

(Их-Уул багийн Засаг дарга)

(Улсын бүртгэгч)

(Газрын даамал)

(Цагдаагийн

хэсгийн төлөөлөгч)

(Эрүүл мэндийн

төвийн дарга)

Нарийн бичгийн дарга

(Хүнс, жижиг дунд үйлдвэр,

хоршооны асуудал

хариуцсан мэргэжилтэн)

2. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний ач холбогдол, үр нөлөөг нутаг дэвсгэртээ

хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд даалгасугай.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан зорилгоор “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг эхлүүлэх төв, орон нутгийн нэгдсэн арга хэмжээ, иргэдтэй уулзалт хийх орчин нөхцлийг хангахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай..

ДАРГА



Б.ГАНБАЯР

**“ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-ИЙ ХҮРЭЭНД ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БАЯН ТАЛ СУМАНД АЖИЛЛАСАН АЖЛЫН ХЭСГИЙН ГҮЙЦЭТГЭСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2024.05.31

Баян тал

(Тайланг дараах бүтэц, агуулгын дагуу холбогдох мэдээллийг дэлгэрэнгүй, бүрэн, үнэн зөв, тодорхой, ойлгомжтой бичсэн байна. Холбогдох зураг, баримтыг тайланд оруулна. Шаардлагатай бол нэмэлт агуулгыг тусгаж болно.

Тайлангийн оршил хэсэгт тус ажлын хэсэг хэдэн хүний бүрэлдэхүүнтэй, ямар байгууллагын хэн хэн ажилласан, хэднээс хэдний хооронд ажилласан талаар дурдана.)

Говьсүмбэр аймгийн Баян тал суманд дараах бүрэлдэхүүнтэй баг ажилласан. Үүнд:

№	Багт гүйцэтгэх үүрэг	Овог нэр	Ажилладаг байгууллага	Ажилласан хугацаа	Хоног
1	Багийн ахлагч	Зундуйн Болдбаатар	Хилийн цэргийн 0164 дүгээр анги, тасгийн дарга	5 сарын 16-аас 31	16
2	Гишүүн	Шүрэнчулууны Цэрэндулам	МУИС-ийн Бизнесийн сургууль, ахлах багш	5 сарын 20-оос 31	12
3	Гишүүн	С.Оюунтүлхүүр	Баян тал сум, хоршоо хариуцсан мэргэжилтэн	5 сарын 16-аас 31	14
4	Жолооч	Бэгзээгийн Гэрэлсайхан	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	5 сарын 16-аас 31	16

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр

(Тайлангийн энэ бүлэгт ажлын хэсгээс сумын Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлсэн ажлын талаар, орон нутгийн байгууллагаас гаргасан шийдвэр, хийсэн ажил, үзүүлсэн дэмжлэг, туслалцаа, ажлын хэсгийн ажлын зохион байгуулалт, явсан маршрут, нийт явсан км-ын талаар)

Говьсүмбэр аймгийн Баян тал сумын засаг дарга Б.Ганбаяраар батлуулсан захирамжаар сумын засаг даргын орлогч Э.Эрхэмбаатараар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан хуралдаж, сумын малчин өрхөд хоршооны талаарх мэдээллийг хэрхэн хүртээмжтэй танилцуулах, сурган зөвлөх ажлын төлөвлөгөө гарган ажилласан.

Төлөвлөгөөний дагуу “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”, Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо хөдгөөн”-ий ач холбогдлыг Баян тал сумын малчин өрхөд танилцуулах, анхан шатны хоршоо байгуулахад сурган зөвлөх, хоршин ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилготой дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Эхний ээлжинд сумын засаг даргын тамгын газрын албан хаагчдад нэгдсэн байдлаар, төвөөс алслагдсан, хурал цуглаанд ирдэггүй зарим малчин өрхүүдэд очиж “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий талаар мэдээлэл хүргэх
- “Лүн”, “Их уул” баг тус бүр дээр малчдын уулзалт зохион байгуулах, мэдээлэл хүргэх
- “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий нээлтийн арга хэмжээг малчдын зөвөлгөөнтэй хамтруулан соёлын төвд зохион байгуулах, сумын төвийн төрийн албан хаагч, малчдад танилцуулга хийх, Улсын бүртгэл, Төрийн банк, Газрын албаны төлөөллөөр нэмэлт мэдээлэл хүргүүлэх

- Хоршоо байгуулах хүсэл, сонирхолтой иргэдийг сумын нутгийн удирдлагын ордны иргэдийн танхимд хүлээн авч ганцаарчилсан уулзалт хийж, зөвлөгөө өгөх
- Хоршоо байгуулахад бүрдүүлэх бичиг баримт, бизнес төсөл боловсруулах тооцооны ажилд зөвлөн туслах ажлуудыг хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотоос ирсэн ажлын хэсгийн 3 албан хаагчийг Засаг даргын тамгын газрын 3 давхарт 2 өрөөнд байрлуулж, суурин компьютер, "Гэр" интернетийн төхөөрөмж өгч, ажиллах нөхцөл бололцоог хангасан.

Албан ажилд ашиглаж байгаа 48-77 УАТ дугаартай Ланд-200 автомашинд GPS, суурилуулж, өдөр бүр явсан км-ыг тэмдэглэн багийн ахлагчаар гарын үсэг зуруулж, компьютерт "Horshoo" программыг суулган танилцуулга хийсэн өрхүүдийн судалгааг шивж тайлагнасан. Багийн засаг дарга нараар хөдөө ажиллах маршрут гаргуулан явж, нийт 1302 км зам туулсан. Хөдөө ажиллах хугацааны 2 өдөр нь бороо орж замын нөхцөл байдал хүндрэлтэй байсан.

Хоёр. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ний талаар зохион байгуулсан сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааны чиглэлээр

- (Тайлангийн энэ бүлэгт ажлын хэсгээс сумын хэдэн багийн хичнээн өрхөд яриа таниулга хийж, мэдээлэл өгсөн, нийт хэдэн удаа сургалт, уулзалт зохион байгуулсан, үүнд хичнээн иргэн хамрагдсан, орон нутгаас хамтран ажилласан албан хаагчийн талаар бичиж, ажилласан баг бүрээр өрхийн тоог нэгтгэж хүснэгтээр оруулна.)

Малчдын анхан шатны шинэ хоршоо байгуулах, хөрөнгө оруулалтын зээлд хэрхэн хамаарах талаар 5 төрлийн сургалт зохион байгууллаа.

Энэхүү ажлын хүрээнд мэдээллээр хангасан малчин өрхийн тоо 81, иргэд, төрийн албан хаагчид 103, хоршоо байгуулахаар шийдвэрлэсэн 21 малчин өрхөд зөвлөн туслах, аргачлал, зөвлөмжөөр хангах ажлыг хийж гүйцэтгэсэн. Сумаас хоршооны мэргэжилтэн Г.Оюунтүлхүүр, багийн дарга Э.Түмэн-Эрдэнэ, Т.Ган-Эрдэнэ нар хамтран ажилласан.

Сургалт	Хамрагдсан		Лүн баг	Их уул баг
	малчин өрх	иргэд		
Сумын засаг даргын тамгын газрын албан хаагчдад	-	8	8	-
"Их уул" багт	16	21	-	45
Лүн" багт	19	26	37	
Малчдын зөвлөгөөнд	25	16	19	22
Малчин өрхүүдэд хүрч үйлчлэхэд	21	32	23	30
Нийт	81	103	87	97

- (Хоршоо шинээр байгуулах, шинэчлэн бүртгүүлэхтэй холбоотойгоор баримт бичиг бүрдүүлэх, хоршооны нэрийг цахимаар баталгаажуулах гэх зэргээр хэдэн малчин өрх, иргэнд зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн талаар, мөн хийсэн ажлын үр дүнг дүгнэж, нийт ... хоршоо шинээр бүртгүүлсэн, нийт... хоршоо шинэчлэн бүртгүүлсэн, дундын хоршооны талаар г.м бичнэ.)

Сумын хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг 1, зогсонги байдалтай 3, шинээр байгуулагдсан 2, нийт 6 хоршоо байна.

Хоршоо шинээр байгуулах, шинэчлэн бүртгүүлэхтэй холбоотойгоор баримт бичиг бүрдүүлэх, хоршооны нэрийг баталгаажуулах зэргээр 21 малчин өрхөд зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн.

Шинээр "Ямбат талын есөн цацал", "Мажет малчид" гэсэн 2 хоршоо байгуулагдсан.

"Оорцог элгэн", "Ямбат талын есөн цацал", "Мажет малчид" хоршоод хөрөнгө оруулалтын зээлд хамрагдахаар бэлтгэлээ хангаж байгаагаас "МАЖӨТ малчид" хоршоо 400,0 сая төгрөгийн зээл авах бизнес төслөө боловсруулсан.

"Оорцог элгэн", "Цагаан айраг", "Мажет малчид" хоршоод газар эзэмших хүсэлтээ гарган газрын даамалд өгч, судлуулж байна.

"Шинэ хоршоо хөдөлгөөн" гэсэн 1м х 1,5 м хэмжээтэй анонсыг хулдаасан хэвлэлээр хэвлүүлж сургалтуудад ашигласан.

Дөрөв. Хоршооны зээл, малжуулах зээл олгуулах, зээлийн батлан даалт гаргуулах чиглэлээр:

(Тайлангийн энэ бүлэгт ажлын хэсгээс хэдэн өрхийн хэдэн иргэн ямар зориулалтаар хичнээн төгрөгийн зээл авах хүсэлт гаргасан, хүсэлт гаргах, материал бүрдүүлэхэд зөвлөн тусалж хамтран ажилласан, нийт хэдэн хоршоо ямар зориулалтаар хичнээн төгрөгийн зээл авах хүсэлт гаргасан, хэдэн хоршоо хэдэн төгрөгийн зээл авсан, үүнээс хэд нь банкнаас, хэд нь Малжуулах төслөөс авсан, эдгээрийн хэд нь Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргуулсан г.м бичнэ.)

"МАЖӨТ малчид" хоршоо 14 гишүүнтэйгээс 8 малчин өрхөд хашаа хороо сайжруулах, хөргүүртэй контейнер, ковш авах, худаг гаргах, мал худалдан авч тарга тэвээрэг авхуулан нядалж, махны хэрэгцээнд нийлүүлэх зориулалтаар 400,0 сая төгрөгийн зээл авах бизнес төсөл боловсруулахад зөвлөн тусалсан.

Зээл авахад бүрдүүлэх материалын талаар зөвлөгөө өгч, загвар маягтуудыг бөглөж байна. Малчин гишүүд өөрийн хөрөнгөөр барьцаа бүрдүүлэх тул зээлийн батлан даалтын санг ашиглахгүй.

Тав.Газар эзэмшүүлэх чиглэлээр

(Тайлангийн энэ бүлэгт хэдэн хоршоо ямар зориулалтаар хэдэн га газар хүсч хүсэлт гаргасан, үүнээс хэдэн өрхөд хэдэн га газар олгогдсон талаар бичнэ)

"Оорцог элгэн" хоршоо нядалгааны цех, зоорийн өргөтгөл, "Цагаан айраг" хоршоо цагаан идээ боловсруулах, худалдаалах цэг, "Мажет малчид" хоршоо малын хашаа саравч барих, мал тарга тэвээрэг авхуулах, бэлчээрийг хуваарьтай ашиглах зорилгоор тус бүр 5 га газар эзэмших хүсэлтээ гарган судлагдаж байна.

Зургаа.Үр дүн, дүгнэлт

(Тайлангийн энэ бүлэгт суманд ажилласан бүх ажлаа нэгтгэн дүгнэж, текст болон тоогоор илэрхийлж бичнэ)

Суманд 5 төрлийн сургалт зохион байгуулж, 81 малчин өрх, 103 иргэн, 6 хоршоонд "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий талаар яриа танилцуулга хийж, хоршооны талаар 3 ном, гарын авлага судлаж, 2 удаа илтгэлийн слайд шинэчилж, хоршоо байгуулах, бизнес төсөл бичих талаар 21 өрхөд зөвлөн туслаж, 2 хоршоо шинээр байгуулж, 1302 км зам туулж, 117 цаг зарцуулан малчин өрхүүдэд хүрч үйлчилсэн.

Долоо. Шинэ хоршоо хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал

(Тайлангийн энэ бүлэгт ажлын хэсгээс суманд ажиллахад тулгарч байсан асуудал, Шинэ хоршоо байгуулах, зээл авах, газар авах зэрэг ажиллагаанд тулгарч байсан асуудлуудын талаар бичнэ.)

Малчид сумын төвдөө ойр байрлалтай, өнгөрсөн өвлийн зуданд нийт малын 30,6 хувийг алдсан, мал аж ахуйн үйлдвэрлэлээр амьжиргаагаа залгах бололцоо муудснаас мал дээр байгаа айлууд ихэвчлэн 1-2 хүнтэй, эхнэр хүүхдүүд нь сумын төвд ажиллаж, сурч байна. Иймээс хоршооны мэргэжилтэн бүх малчин өрхүүдээ Мессенжер группт оруулж, мэдээллийг шуурхай хүргэн ажиллаж байгаа ч сумаас зохион байгуулж байгаа ажилд хамрагдах байдал хангалтгүй байсан.

Ноос ноолуурын урамшууллыг хоршоодоор дамжуулан олгох чиглэлээр хийгдсэн арга хэмжээний үр дүнд 1 малчин хэд хэдэн хоршооний гишүүн болсон байгаа нь шинээр хоршоо байгуулах үйлдэлд хугацаа алдах нөхцлийг бий болгосон.

Зээл авахад бизнес төсөл боловсруулах мэдлэгтэй хүн ховор байгаа нь мөн хугацаа алдах, цаашлаад газрын төсөл сонгон шалгаруулалтад сөргөөр нөлөөлж байна.

Сум болгонд хоршоо үүссэнээр малын үнэ хэт өсөх, олдоц ховордох, нэг чиглэлийн хоршоод ойр ойрхон байрласнаас ашигтай ажиллах бололцоог бууруулах эрсдэлтэй.

Мөн сургагч 2 багшийн албан байгууллагад албан бичгүүд албан ёсоор хүрээгүй, томилолтын зардлаа одоо хүртэл авч чадаагүй байгаа асуудлыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хэлсэн боловч хаанаа гацаад шийдвэрлэгдэхгүй байгаа нь тодорхойгүй байсаар байна.

Найм. Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх, шинэ хоршоодыг хөгжүүлэх чиглэлээр цаашид авах арга хэмжээний санал

(Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх, өргөжүүлэх, малчдыг малжуулах, малчин өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр цаашид сум, орон нутгийн зүгээс, мэргэжлийн байгууллагаас, яамдаас, Засгийн газраас авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа арга хэмжээний талаар бичнэ.)

-Малчдын хэлж байгаагаар аймаг, сумаас байнгын сургалт, мэдээллээр хангах, зөвлөн туслах, Шинэ хоршоо хөдөлгөөнийг улс төржүүлэхгүй, тогтвортой дэмжлэг, туслалцаа үзүүлэн ажиллах шаардлагатай

-Жишиг хоршоодын үйл ажиллагааг харуулсан, шинжлэх ухаанчаар малын үүлдэр угсааг хэрхэн сайжруулах, шинэ технологийг түгээсэн бичлэгүүд хийж танилцуулж байх

-Хөдөө аж ахуйн биржээр худалдан авагч талаа төвөггүй олж болдог үйл ажиллагааг практикт хэрэгжүүлэх, ө.х хэрэгцээ хаана байгаа талаар мэдээлэл өгдөг байх

-Малын түүхий эдийн үнийг нэмэгдүүлэх, хоршоод экспортлох боломж олгох

Тайлан бичсэн:

Багийн ахлагч: Сургагч багш

Мэргэжилтэн

З.Болдбаатар

С.Оюунтүлхүүр





